MERIT
A CESO AND WUSC PROGRAM

Жендэрийн дүн шинжилгээнд өргөнөөр хэрэглэгддэг үгс

Мишэл Филион, Төрийн удирдлагын зөвлөх

Агуулга

- Хүйс ба жендэр
- Өрөөсгөл ойлголт, эрэгтэй хүйсийг голлох хандлага
- Жендэрийн мэдрэмжгүй байдал
- Хүйсээр ангилсан шалгуур үзүүлэлт ба хэмжигдэхүүн
- Жендэрийн аудит
- Тэгш байдал, тэгш эрхийн бодлого

mfilion@ign.quebec

Жендерийн дүн шинжилгээн дэх хүйсийн асуудал

- Хүйс гэдэгт хүн болон амьтны биологийн шинж чанарын цогцыг ойлгоно. Энэ нь үндсэндээ хромсом, генийн мэдээлэл, дааврын түвшин ба ажиллагаа, үржлийн буюу бэлэг эрхтэн зэрэг бие махбодын болон биологийн шинж чанаруудтай холбоотой байдаг.
- Хүйс нь ихэнхдээ эрэгтэй ба эмэгтэй гэсэн 2 ангилалд хуваагддаг.

mfilion@ign.quebec

Жендер

- Жендэр гэдэг нь охид, эмэгтэйчүүд, хөвгүүд, эрэгтэйчүүд, өөр жендэрийн хүмүүст нийгмийн зүгээс тохоосон үүрэг, зан төлөв, илэрхийлэл ба дүр төрх юм.
- Энэ нь хүмүүс өөрсдийгөө болон бусдыг хэрхэн үзэж байгаа, хэрхэн биеэ авч явах болон харилцах, нийгэм дэх эрх мэдэл ба нөөц баялгийг хуваарилахад хэрхэн оролцох байдалд нөлөөлдөг.

mfilion@ign.quebec

Өрөөсгөл хандлага

- Өрөөсгөл хандлага гэдэг нь нэг зүйл, хүн, эсвэл хүн амын бүлэгт бусадтай нь харьцуулахад ихэвчлэн шударга бусад тооцогдохуйц тэнцвэргүй байдлаар илүүд үзэх эсвэл эсэргүүцэх хандлага юм.
- Ямар ч соёлын орчинд хүмүүст бага балчир наснаас нь эхлэн өрөөсгөл хандлага мэдэгдэхгүйгээр суудаг.
- Хүмүүс аль нэг хүн, гарал угсаатан, бэлгийн чиг баримжаа, дүр төрх, үндэстэн, шашин шүтлэг, нийгмийн анги давхарга, улс төрийн нам, онолын ухагдахуун, эрдэм шинжилгээний хүрээн дэхь ойлголт, төрөл зүйлийг эсэргүүцсэн эсвэл таашаасан өрөөсгөл ойлголттой болж болно.

mfilion@ign.quebec

Эр хүйсийг голлох өрөөсгөл хандлага

- Хүмүүс орчин үеийн нийгэмд жендэрийн тэгш бус байдал байхгүй болсон гэж үздэг ч жендэрээр ялгаварлан гадуурхах үзэгдэл байсаар байгааг олон судалгаа нотлож байна.
- Бусад бүх зүйл дээр эн тэнцүү байсан ч эрчүүдтэй харьцуулбал эмэгтэйчүүд тодорхой талбарт ялгаварлагдсан хэвээр буйг судалгаа бэлхнээ харуулдаг. Магадгүй энэ нь ерөнхийдөө эрчүүд илүү чадварлаг гэж үздэг (илүү ур чадвартай гэдгийг нь нотлох баримт байхгүй байсан ч гэлээ) хандлагаас шалтгаалсан байх талтай.

mfilion@ign.quebec

Бодлогод эр хүйсийг голлох хандлага

- Аливаа бодлогод эр хүйсийг голлосноор “жендэрийг харгалзан үзэлгүйгээр эрэгтэй хүний өнцгөөс асуудлыг харж шийдвэрлэхэд” хүргэдэг.
- Энэ нь феминист онолчдын тодорхойлсноор голдуу эрэгтэй нийгэм судлаачид нь зөвхөн эрэгтэй хүний өнцгөөс асуудалд анхаарал хандуулж, гарсан үр дүн нь эмэгтэйчүүдэд ч мөн адил хамаарна гэж үзэх үзэл хандлага юм.
- Энэ хандлага нь бодлого боловсруулах гэх мэт ямар ч төрлийн оюуны ажилд илүү ажиглагддаг.

mfilion@ign.quebec

Жендэрийн мэдрэмжгүй байдал

- Жендэрийн мэдрэмжгүй байдал гэдэг нь биологийн болон түүхээс уламжлагдан тогтсон ялгаатай байдлыг нь үл харгалзан бүх жендэрийн хүмүүст адилхан хандах байдлыг илэрхийлэхэд ашигладаг нэр томьёо юм.
- Нүүрэн дээрээ тэгш байдал тогтоохын төлөө ахиц гаргах сайхан алхам хийж байгаа мэт харагдаж болох ч угтаа хүмүүст яг адилхан хандах нь сөрөг үр дагавартай.
- Ялгаатай байдлыг анхааралгүй орхигдуулснаар эмэгтэйчүүд тэгш эрх эдлэж чадахгүйд хүрдэг.

mfilion@ign.quebec

Хүйсээр ангилсан шалгуур үзүүлэлт

- Эрэгтэй, эмэгтэй хүйсээр нь ангилан цуглуулж, тайлагнадаг аливаа мэдээ, тоон мэдээлэл юм.

mfilion@ign.quebec

Жендэрийн аудит

- Жендэрийн аудит нь бодлого, хөтөлбөр, зохион байгуулалтын бүтэц, үйл ажиллагааны дүрэм журам (шийдвэр гаргах үйл явцыг оруулаад) болон холбогдох төсөвт жендэрийн тэгш байдал хэдий хэр үр дүнтэй тусгагдсаныг үнэлдэг.

mfilion@ign.quebec

Тэгш байдал

- Жендэрийн тэгш байдал гэдэг нь эмэгтэй, эрэгтэй хүмүүс бүх зүйлд ижил байр суурь, статустай байхыг хэлнэ.
- Жендэрийн тэгш байдал гэдэг нь эмэгтэй, эрэгтэй хүмүүс эрхээ бүрэн эдлэх тэгш нөхцөлөөр хангагдаж, үндэсний, улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын хөгжилд хувь нэмрээ оруулах болон түүний үр өгөөжөөс хүртэх тэгш боломжоор хангагдана гэсэн үг юм.

mfilion@ign.quebec

Тэгш эрх

- Жендэрийн тэгш эрх нь эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн дунд шударга байдлыг тогтоох үйл явц юм.
- Шударга байдлыг хангахын тулд эмэгтэй, эрэгтэй хүмүүс амжилт олох шударга, тэгш боломж бүхий орчин нөхцөлд ажиллаж, амьдрахад нь саад болдог уламжлагдан тогтсон түүхэн болон нийгмийн сөрөг хүчин зүйлсийг тэнцэтгэх арга хэмжээг хэрэгжүүлэх нь зүйтэй.
- Тэгш эрх нь тэгш байдал тогтох үндэс юм.

mfilion@ign.quebec

Жендэрийн тэгш байдал, тэгш эрхийн бодлого

Энэ бодлого нь дараах зорилготой:

- Нийгэмд тогтвортой хөгжлийг бий болгохын тулд шийдвэр гаргахад эмэгтэйчүүдийн оролцоог эрэгтэйчүүдтэй ижил түвшинд хүргэх;
- Эмэгтэйчүүд, охидод хүний эрхээ бүрэн эдлэхэд нь туслах;
- Хөгжлийн үр шим, нөөцөөс хүртэх, хяналт тавих байдалд жендэрийн тэгш байдлыг хангах.

mfilion@ign.quebec



Merci.